



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 1178

Номгон

“Усны үнэлэмж, үнэ цэнэ” сэдэвт сарын аян зарлах тухай

“Байгалийн амьтан, ургамал хамгаалах дэлхийн өдөр”, “Дэлхийн ойн өдөр”, “Дэлхийн усны өдөр”, “Дэлхийн цаг уурын өдөр”, “Мазаалай хамгаалах өдөр”-үүд нь жил бүрийн 3 дугаар сард тохиодогтой холбогдуулан “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалт, “Баянхонгор аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 2.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэд, төрийн албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад “Усны үнэлэмж, үнэ цэнэ” сэдэвт 1 сарын аяныг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Тус аяны хүрээнд Байгаль орчны тэмдэглэлт өдрийн ач холбогдлыг иргэдэд сурталчлан таниулж, усны үнэ цэнэ, зүй зохистой хэрэглээ, экологийн боловсролын талаарх мэдлэг, хандлага, төлөвшил олгох олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагууд, сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН